

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.Менежментийн захидал.....	9
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АХМАД НАСТНЫ
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГА
Л.ЭРДЭНЭХҮҮ ТАНАА

2020.02.27 № 06/613
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ахмад настны үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ахмад настны үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Ахмад настны үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төвийн дарга Л.Эрдэнэхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, санхүүгийн цахим баримт, анхан шатны бүртгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ахмад настны үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Нийслэл-Аудит” ХХК-ын аудитор Г.Жаргал, шинжээч Д.Доржпүрэв, аудиторын туслах Д.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ахмад настны үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Нийслэл-Аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдийн эрхийг хүндлэн дээдэлж, сэргээн засах эмчилгээ сувилгаа үзүүлэх, тодорхой хөтөлбөрүүдэд хамруулан чадавхжуулах, хөгжүүлэх, цаашид удаан амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, амьдрах ухааны дадал чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэх, аюулгүй орчноор хангахад оршино.

Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үйлчлүүлэгчдийг эрүүл аюулгүй, таатай орчинд амьдруулах
- Үйлчлүүлэгчдэд эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хувцас, эм тариа, ахуйн хэрэгслээр хангах.
- Үйлчлүүлэгч бүрийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, тэдний хөгжил, хамгааллын шаардлагатай бүх үйлчилгээг үзүүлэх
- Үйлчлүүлэгч бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ асаргаа сувилгааг үзүүлэх үйлчилгээ нь хүнд сурталгүй, авилгаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй байх зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулах

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ахмад настны үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Ахмад настны үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Ахмад настны үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд 12 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,367,078.6 мянган төгрөгийн 1 хувиар тооцон 13,670.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 31,652.0 мянган төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ахмад настны үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 526,611.7 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	785.1	785.1
Авлага	64,000.0	59,690.3	(4,309.7)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	729,896.2	781,174.6	51,278.3
Үндсэн хөрөнгө	10,659,212.0	11,138,069.9	478,857.9
Нийт хөрөнгө	11,453,108.2	11,979,719.9	526,611.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,453,108.2	11,979,719.9	526,611.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,453,108.2	11,979,719.9	526,611.7

Авлага дансны үлдэгдэлд “Өгөөмөр баян булаг” ХХК-аас авах махны авлага 43,215.4 мянган төгрөг, Сангийн яамнаас авах тэтгэвэр тэтгэмжийн 30 хувийн орлогын авлага 15,189.0 мянган төгрөг, Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтсээс авах 1,285.9 мянган төгрөгийн авлага байна. Үүнээс 2017 онд үүссэн 43,215.4 мянган төгрөгийн махны авлагыг барагдуулахаар төв аймгийн шүүхэд хандсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл үнэ төлбөргүй авсан 61,187.9 мянган төгрөгийн бараа материал болон худалдан авалттай холбоотой өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь авто тээврийн хэрэгсэл 36,000.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 431,677.9 мянган төгрөг, тавилга эд хогшил 30,821.9 мянган төгрөг, биет бус хөрөнгө 342,050.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 53,428.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 442,071.8 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Үндсэн хөрөнгө тайлант жилд 361,692.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Биет бус хөрөнгө 342,050.0 мянган төгрөгөөр өссөн нь газар эзэмших эрхийн гэрчилгээг шийдвэрлүүлж дахин үнэлгээний дүнгээр нэмэгджээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулж 2,624,243.3 мянган төгрөгийг олгохоос, 1,946,746.0 мянган төгрөгийг улсын төсвөөс,

677,497.3 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого 6,028.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 92,706.7 мянган төгрөг нийт 98,735.5 мянган төгрөг давуулан биелүүлсэн нь ахмад настны сувиллын сувилуулагчдын тоо өссөнөөс шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,591,279.0 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа ба зарцуулагдаагүй үлдэгдэл нь 130,914.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 19,535.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3,575.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь орон тоо дутуутай холбоотой, байр ашиглалтай холбоотой зардал 2,324.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь сувиллын үйл ажиллагаа жигдрээгүйгээс шалтгаалсан, томилолтын зардал 4,083.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь томилолтоор ажиллах төлөвлөсөн ажлууд хийгдээгүйтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос 80,784.5 мянган төгрөгийг, үүнээс урсгал зардалд 80,784.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 448,081.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 448,081.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс “Өгөөмөр баян булаг” ХХК-с авах 43,125.4 мянган төгрөгийн махны авлагыг бүртгээгүй нь Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 5.1.3-д Жинхэнэ хэрэгжсэн байх 5.1.4 үнэн зөв байх, гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг залруулсан.

2. Эм боох материал данснаас аж ахуйн материал дансанд 2,921.1 мянган төгрөгийг шилжүүлэн бүртгэхдээ үнэ төлбөргүй орлого дансыг нэмэгдүүлж бараа материалын зардлыг 2,921.1 мянган төгрөг өсгөсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

3. Газрын дахин үнэлгээний 342,050.0 мянган төгрөгийн дүнгээр засгийн газрын оруулсан капиталыг нэмэгдүүлсэн нь Сангийн сайдын 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын “4.42 Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн хэмжээгээр дахин үнэлгээний нэмэгдэл дансны кредитэд бичнэ.” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Туслах аж ахуйн мал (үхэр, адуу, хонь ямаа)-г санхүүгийн байдлын тайланд "Бараа материал" бүлэгт тусгасан бүртгэл нь УСНББОУС-27-д "9-д Биологийн хөрөнгө нь амьд амьтан, ургамал", "16-д энэ стандартын 34-р зүйлд тодорхойлсон бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй байгаагаас бусад бүх тохиолдолд биологийн хөрөнгийг анх

хүлээн зөвшөөрөх үед болон тайлангийн үе бүрд борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжинэ...” гэсэн заалтыг Сангийн яам, “Санхүүгийн тооцоолох” ХХК-д программыг тайлант жилд орлогодож авсан бараа материал, үндсэн хөрөнгийг шилжүүлэн бүртгэх бичилтийг шууд хийдэг болох зэрэг асуудлыг анхаарал татах бусад асуудлаар дамжуулан уламжилж байна.

Тэтгэвэр тэтгэмжийн 30 хувийн орлогыг цаг хугацаанд нь төрийн сангийн харилцах дансанд тушааж байгаа эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Ахмад настны үндэсний төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 150 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, “Өгөөмөр баян булаг” ХХК авах 43,215.4 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгах тухай 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ахмад настны үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн 448,081.6 мянган төгрөгийн алдааг бүрэн залруулсан тул Ахмад настны үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авалтын цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс аваагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Маягт заавар батлах тухай” тушаалын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Байгууллагын зардал баримтаар нотлогдохгүй байх, ажилтан албан хаагч нь хувь хүнээр баримтыг авч татварын буцаан олголт авах эрсдэлтэй байна.

1.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс авахдаа байгууллагын регистрийн дугаараар цахим баримтыг авч байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хойшид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

2. Бараа материалын тайлантай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Эмийн сан, хүнсний материалын нярав, эд хариуцагч нар сар бүр тайлан гаргаагүй, агуулахын болон эмийн нөөцийн үлдэгдлийн бүртгэл хөтөлдөггүй, шаардах хуудас, захиалгын хуудас зэрэг тоо бүртгэлээр санхүүгийн программд шивж, нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн “4.3-д Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.1-д анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2.журналд бичих; 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах; 14.3.5.санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, няравт тавих дотоод хяналт сул байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Агуулахын бүртгэлийг хөтөлж байх, няравт тогтмол хяналт тавих.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хойшид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	793,896,364.31	841,650,066.37
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		785,100.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		785,100.00
31110	Төгрөг		785,100.00
33	АВЛАГА	64,000,000.00	59,690,339.79
3351	Байгууллагаас авах авлага	64,000,000.00	59,690,339.79
35	БАРАА МАТЕРИАЛ	729,896,364.31	30,459,451.90
351	Түүхий эд материал	25,438,179.84	30,459,451.90
35130	Эм боох материал	25,438,179.84	30,459,451.90
354	Хангамжийн материал	608,002,574.47	647,395,174.68
35410	Бичиг хэргийн материал	593,250.00	820,200.00
35420	Аж ахуйн материал	253,012,296.69	342,408,811.55
35460	Хүнсний материал	241,643,887.78	235,442,563.13
35470	Бусад хангамжийн материал	112,753,140.00	68,723,600.00
35600	Мал, амьтад	96,455,610.00	103,320,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,659,211,965.16	11,138,069,920.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,659,211,965.16	11,138,069,920.58
392	Биет хөрөнгө	10,606,034,365.24	10,743,034,820.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,391,914,798.08	10,391,914,798.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	(488,140,774.52)	(681,504,214.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	208,598,764.00	244,598,764.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(139,105,587.68)	(201,175,381.96)
39205	Машин тоног төхөөрөмж	775,769,153.20	1,207,447,107.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(200,633,038.54)	(292,331,640.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,502,450.00	142,324,410.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,871,399.30)	(68,239,021.99)
393	Биет бус хөрөнгө	53,177,599.92	395,035,099.88
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(385,000.08)	(577,500.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	52,792,600.00	394,842,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,453,108,329.47	11,979,719,986.95
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,453,108,329.47	11,979,719,986.95
51	Засгийн газрын хувь оролцоо	11,453,108,329.47	11,979,719,986.95
51101	Өмч: - төрийн	922,858,232.00	922,858,232.00
512	Хуримтлагдсан үр дүн	9,725,324,258.43	9,909,885,915.91
51210	Өмнөх үеийн үр дүн	9,592,184,188.75	9,725,324,258.43
51220	Тайлант үеийн үр дүн	133,140,069.68	184,561,657.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	804,925,839.04	1,146,975,839.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,453,108,329.47	11,979,719,986.95

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,935,813,648.25	3,349,757,255.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,139,366,748.25	1,322,226,795.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,139,366,748.25	1,322,226,795.00
	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,139,366,748.25	1,322,226,795.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		134,728,846.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	686,244,840.00	656,427,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	453,121,908.25	531,070,846.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,796,446,900.00	2,027,530,460.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,796,446,900.00	1,946,746,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,796,446,900.00	1,946,746,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		80,784,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,750,760.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		75,043,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,802,673,578.57	3,165,195,597.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,802,673,578.57	3,165,195,597.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,632,258,556.72	3,038,134,809.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	803,890,009.00	987,910,935.00
210101	Цалин	672,007,319.00	773,259,302.00
210102	Нэмэгдэл цалин	75,961,479.00	163,891,137.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,486,135.00	50,256,300.00
210105	Гэрээтийн цалин	19,435,076.00	504,196.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,529,596.15	121,070,177.10
210201	Тэтгэврийн даатгал	81,981,762.90	85,125,251.10
210202	Тэтгэмжийн даатгал	2,909,566.73	7,175,817.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,636,958.42	7,184,513.00
210204	Ажилгүйдлийн даатгал	727,391.68	1,962,189.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,273,916.42	19,622,407.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	265,091,644.48	268,357,022.00
210301	Гэрэл, цахилгаан	87,331,161.00	98,364,222.00
210302	Түлш, халаалт	154,894,000.00	154,894,000.00
210303	Цэвэр, бохир ус	22,866,483.48	15,098,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	72,681,686.00	128,860,750.00
210401	Бичиг хэрэг	2,237,250.00	3,577,070.00
210402	Тээвэр, шатахуун	37,615,150.00	55,860,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,590,920.00	2,267,010.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	7,275,000.00	10,238,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,963,366.00	56,917,710.00
	Нормативт зардал	874,617,813.05	939,261,144.40
	Эм	57,339,343.94	75,250,500.94

	Хоол	692,501,885.80	729,443,209.65
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	124,776,583.31	134,567,433.81
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,260,226.00	82,605,301.33
210604	Урсгал засвар	86,260,226.00	82,605,301.33
2107	Томилолт, зочны зардал	3,042,000.00	5,880,000.00
210702	Дотоод албан томилолт	3,042,000.00	5,880,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,897,360.00	17,609,108.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,475,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	739,457.00	831,084.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	483,333.00	405,024.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	304,570.00	717,000.00
210807	Газрын төлбөр	1,895,000.00	12,656,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	424,248,222.04	486,580,371.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,960,789.00	124,888,413.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	320,287,433.04	361,691,958.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	170,415,021.85	127,060,788.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,986,000.00	11,335,900.00
213209	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	4,985,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		6,350,000.00
2134	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	165,429,021.85	115,724,888.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	165,429,021.85	115,724,888.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	133,140,069.68	184,561,657.48

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,482,691,740.00	2,804,057,210.00
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	686,244,840.00	776,526,750.00
	Нийтлэг татварын бус орлого	686,244,840.00	776,526,750.00
	Төсвийн байгууллагын өөрийн орлого	686,244,840.00	776,232,846.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		134,728,846.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	686,244,840.00	641,504,000.00
120009	Бусад орлого		293,904.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 796,446,900.00	2,027,530,460.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1 796,446,900.00	1,946,746,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 769,446,900.00	1,946,746,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		80,784,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,740,760.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		75,043,700.00
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2 484,877,589.00	2,803,272,110.00
	УРСГАЛ ЗАРДАЛ	2 484,877,589.00	2,803,272,110.00
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 250,432,567.15	2,661,021,427.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	803,890,009.00	987,910,935.00
210101	Үндсэн цалин	672,007,319.00	773,763,498.00
210102	Нэмэгдэл	75,961,479.00	163,891,137.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,486,135.00	50,256,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,435,076.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,529,596.15	122,355,222.89
210201	Тэтгэврийн даатгал	81,981,762.49	86,410,296.89
210202	Тэтгэмжийн даатгал	2,909,566.73	7,175,817.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,636,958.42	7,184,513.00
210204	Ажилгүйдлийн даатгал	727,391.68	1,962,189.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,273,916.83	19,622,407.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	262,955,161.00	274,505,022.00
210301	Гэрэл, цахилгаан	87,331,161.00	98,364,222.00
210302	Түлш, халаалт	154,894,000.00	154,894,000.00
210303	Цэвэр, бохир ус	20,730,000.00	21,246,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,853,390.00	126,284,370.00
210401	Бичиг хэрэг	2,395,800.00	3,212,020.00
210402	Тээвэр, шатахуун	37,375,850.00	50,648,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,590,920.00	2,267,010.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,275,000.00	14,546,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,215,820.00	55,610,380.00

	Нормативт зардал	844,212,852.00	939,574,448.00
210501	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	51,787,732.00	55,256,518.00
210502	Хоол, хүнс	669,838,720.00	738,017,930.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	122,586,400.00	146,300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,692,410.00	37,741,634.00
210604	Урсгал засвар	59,692,410.00	37,741,634.00
2107	Томилолт, зочны зардал	3,042,000.00	5,880,000.00
210702	Дотоод албан томилолт	3,042,000.00	5,880,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,357,360.00	166,424,936.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		152,096,828.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,475,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	739,457.00	831,084.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	483,333.00	405,024.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	764,570.00	717,000.00
210807	Газрын төлбөр	1,895,000.00	9,375,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,929,789.00	344,860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,929,789.00	344,860.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234,415,021.85	142,250,682.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,986,000.00	11,335,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн	4,986,000.00	4,985,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		6,350,000.00
2134	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	229,429,021.85	130,914,782.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	229,429,021.85	130,914,782.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(2,185,849.00)	785,100.00
225	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	51,348,800.00	
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,348,800.00	
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(53,534,649.00)	785,100.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	53,534,649.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		785,100.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	9,107,490,018.52	10,461,492,840.52
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	870,065,632.00	483,937,190.00	9,107,490,018.52	10,461,492,840.52
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	52,792,600.00	320,988,649.04		373,781,2496.04
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			54,572,889.96	54,572,889.96
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	922,858,232.00	804,925,839.04	9,725,324,258.43	11,453,108,329.47
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		342,050,000.00		342,050,000.00
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			184,561,657.48	184,561,657.48
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	922,858,232.00	1,146,975,839.04	9,909,885,915.91	11,979,719,986.95

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,624,243,300.00	2,591,281,963.89	(32,964,336.11)	98.76
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,624,243,300.00	2,591,281,963.89	(32,964,336.11)	98.76
Бараа үйлчилгээний зардал	2,612,907,400.00	2,580,236,967.89	(32,670,432.11)	98.75
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	992,446,000.00	972,910,935.00	(19,535,065.00)	98.03
Үндсэн цалин	778,001,300.00	758,763,498.00	(19,237,802.00)	97.53
Нэмэгдэл цалин	164,188,400.00	163,891,137.00	(297,263.00)	99.82
Унаа, болон бусад нөхөн олговор	50,256,300.00	50,256,300.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,055,500.00	120,480,222.89	(3,575,277.11)	97.12
Тэтгэврийн даатгал	84,357,900.00	84,535,296.89	177,396.89	100.21
Тэтгэмжийн даатгал	9,924,300.00	7,175,817.00	(2,748,483.00)	72.31
ҮОМШӨ-ний даатгал	7,939,600.00	7,184,513.00	(755,087.00)	90.49
Ажилгүйдлийн даатгал	1,984,800.00	1,962,189.00	(22,611.00)	98.86
Эрүүл мэндийн даатгал	19,848,900.00	19,622,407.00	(226,493.00)	98.86
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	276,829,000.00	274,505,022.00	(2,323,978.00)	99.16
Гэрэл цахилгаан	100,684,000.00	98,364,222.00	(2,319,778.00)	97.70
Түлш халаалт	154,894,000.00	154,894,000.00	-	100.00
Цэвэр бохир ус	21,251,000.00	21,246,800.00	(4,200.00)	99.98
Хангамж, бараа материалын зардал	118,865,600.00	117,772,610.00	(1,092,990.00)	99.08
Бичиг хэрэг	3,237,500.00	3,212,020.00	(25,480.00)	99.21
Тээвэр шатахуун	42,137,200.00	42,137,000.00	(200.00)	100.00
Шуудан холбоо интернэтийн зардал	3,166,200.00	2,267,010.00	(899,190.00)	71.60
Хог хаягдал зайлуулах зардал	14,768,000.00	14,546,200.00	(221,800.00)	98.50
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	55,556,700.00	55,610,380.00	53,680.00	100.10
Нормативт зардал	936,899,500.00	936,001,448.00	(898,052.00)	99.90
Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	56,084,500.00	55,256,518.00	(827,982.00)	98.52
Хоол, хүнс	734,445,000.00	734,444,930.00	(70.00)	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	146,370,000.00	146,300,000.00	(70,000.00)	99.95
Эд хогшил худалдан авах	11,301,300.00	11,247,134.00	(54,166.00)	99.52
Урсгал засвар	11,301,300.00	11,247,134.00	(54,166.00)	99.52
Томилолт зочны зардал	8,307,400.00	4,224,000.00	(4,083,400.00)	50.85
Дотоод албан томилолт	8,307,400.00	4,224,000.00	(4,083,400.00)	50.85
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	143,500,500.00	142,750,736.00	(749,764.00)	99.48
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,700,000.00	128,422,628.00	(277,372.00)	99.78
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	837,500.00	831,084.00	(6,416.00)	99.23
Тээврийн хэрэгслийн татвар	408,000.00	405,024.00	(2,976.00)	99.27
Мэдээллийн технологийн зардал	990,000.00	717,000.00	(273,000.00)	72.42
Газрын төлбөр	9,565,000.00	9,375,000.00	(190,000.00)	98.01
Бараа үйлчилгээний бусад зардал	702,600.00	344,860.00	(357,740.00)	49.08
Бараа үйлчилгээний бусад зардал	702,600.00	344,860.00	(357,740.00)	49.08
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,335,900.00	11,335,900.00	-	100.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн	4,985,900.00	4,985,900.00	-	100.00

Ахмад настны үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,350,000.00	6,350,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,624,243,300.00	2,722,978,846.00	(32,179,236.11)	103.76
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,946,746,000.00	1,815,831,178.89	(130,914,782.11)	100.00
Улсын төсвөөс санхүүжих	1,946,746,000.00	1,815,831,178.89	(130,914,782.11)	100.00
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	677,497,300.00	776,232,846.00	98,735,546.00	114.57
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	128,700,000.00	134,728,846.00	6,028,846.00	104.68
Туслах үйл ажиллагааны орлогоос	548,797,300.00	641,504,000.00	92,706,700.00	116.89
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		785,100.00	785,100.00	

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөг/	
ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		80,784,460.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		80,784,460.00
Бараа үйлчилгээний зардал		80,784,460.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал		15,000,000.00
Үндсэн цалин		11,595,963.00
Нэмэгдэл		3,404,037.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,875,000.00
Тэтгэврийн даатгал		1,875,000.00
Хангамж, бараа материалын зардал		8,511,760.00
Бичиг хэрэг		
Тээвэр шатахуун		8,511,760.00
Шуудан холбоо интернэтийн зардал		
Нормативт зардал		3,573,000.00
Хоол хүнс		3,573,000.00
Эд хогшил худалдан авах зардал		26,494,500.00
Урсгал засвар		26,494,500.00
Томилолт зочны зардал		1,656,000.00
Дотоод албан томилолт		1,656,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		23,674,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		23,674,200.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		80,784,460.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		80,784,460.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,740,760.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		7,043,700.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Ахмад настны үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код:
2019			САГ-2020/77/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ахмад настны үндэсний төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд худалдан авалтын цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс аваагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Маягт заавар батлах тухай” тушаалын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” заалтыг зөрчсөн байна.	-	Зөвлөмж	Төвийн дарга Нягтлан бодогч	Л.Эрдэнэхүү С.Нэргүй
2	Эмийн сан, хүнсний материалын нярав, эд хариуцагч нар сар бүр тайлан гаргаагүй, агуулахын болон эмийн нөөцийн үлдэгдлийн бүртгэл хөтөлдөггүй, шаардах хуудас, захиалгын хуудас зэрэг тоо бүртгэлээр санхүүгийн программд шивж, нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн “4.3-д Нягтлан бодох бүртгэлийн	-	Зөвлөмж	Төвийн дарга Нягтлан бодогч	Л.Эрдэнэхүү С.Нэргүй

	<p>мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.1-д анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2.журналд бичих; 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах; 14.3.5.санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.</p>				
	ДҮН	-			

